



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүүжин театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/054/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025.02.11	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn Аудитор: А.Адилзаяа Утас: 80870886 Цахим хаяг: Adilzayaa@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно.	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮҮХДИЙН
ТЭМҮҮЖИН ТЕАТРЫН ДАРГА
Ж.БАТБОЛД ТАНАА

2025.02.21 № 2/21
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүүжин театрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүүжин театрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага тайлант онд 1 орон тоо дутуу ажилласнаас цалингийн зардал гүйцэтгэлээр 64,455.3 мянган төгрөгөөр хэмнэгдсэн. Мөн төсвийн хөрөнгөөр 73,325.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 550.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 26,000.0 мянган төгрөгөөр дууны фонограмм, жүжгийн зохиол, баримтат кино зэргийг худалдаж авсан бол аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 11-р сарын 18-ны өдрийн 99 дүгээр захирамжид үндэслэн ОНХС-ийн хөрөнгөөр

5020189

d:\2025 он\бичиг хэрэг\тоот\2. а4-албан тоот.docx

20,000.0 мянган төгрөгийн мастер морин хуур, Соёл спорт аялал жуулчлалын яамнаас 1,984.4 мянган төгрөгийн даралтат хөгжим ирснийг орлогод авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд нийт 26 ажил төлөвлөснөөс хэрэгжилтийн хувь 96.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА ТӨРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>208,410,997.68</u>	<u>152,644,159.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	93,863,530.68	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	93,863,530.68	00.00
3121	Төгрөг	93,863,530.68	00.00
31211	Төрийн сангийн харилцах	93,863,530.68	00.00
33	АВЛАГА	3,520,933.00	427,133.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,520,933.00	427,133.00
35	БАРАА МАТЕРИАЛ	111,026,534.00	152,217,026.00
351	Түүхий эд материал	6,099,190.00	6,099,190.00
35110	Тусгай зориулалттай материал	6,099,190.00	6,099,190.00
354	Хангамжийн материал	104,927,344.00	146,117,836.00
35410	Бичиг хэргийн материал	92,100.00	642,100.00
35420	Аж ахуйн материал	4,541,100.00	4,541,100.00
35450	Барилгын засварын материал	240,000.00	240,000.00
35470	Бусад хангамжийн материал	100,054,144.00	140,694,636.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>160,995,193.94</u>	<u>241,618,039.52</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	160,995,193.94	241,618,039.52
392	Биет хөрөнгө	138,059,093.94	192,981,939.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,375,000.00	18,375,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,531,250.00	-5,206,250.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	169,160,451.00	242,696,945.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	116,116,143.37	-141,282,241.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	156,029,396.00	176,579,396.00
39214	Хуримтлагдсан элэгдэл	-89,596,959.69	-99,761,110.25
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,474,500.00	2,474,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,840,900.00	-1,999,300.00
39217	Ном	1,105,000.00	1,105,000.00
393	Биет бус хөрөнгө	22,936,100.00	48,636,100.00
39301	Програм хангамж	2,050,000.00	2,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-875,000.00	-1,175,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,761,100.00	47,761,100.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>369,406,191.62</u>	<u>394,262,198.52</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>369,406,191.62</u>	<u>394,262,198.52</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	369,406,191.62	394,262,198.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	137,949,437.69	137,949,437.69
51101	Өмч: - төрийн	137,949,437.69	137,949,437.69

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
512	Хуримтлагдсан үр дүн	208,355,392.93	233,211,399.83
51210	Өмнөх үеийн үр дүн	208,355,392.93	208,355,392.93
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	24,856,006.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	23,101,361.00	23,101,361.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	369,406,191.62	394,262,198.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,010,136,548.14	1,212,684,669.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,694,800.00	74,877,764.00
120	Нийтлэг татварын бус орлого	93,694,800.00	74,877,764.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,279,800.00	52,893,350.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,769,800.00	52,893,350.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,510,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	916,441,748.14	1,137,806,905.25
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	798,259,448.14	1,004,653,005.25
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	798,259,448.14	1,004,653,005.25
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	118,182,300.00	133,153,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	118,182,300.00	133,153,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	837,383,456.22	1,187,828,662.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	837,383,456.22	1,187,828,662.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	677,571,777.64	995,495,142.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	384,810,004.00	627,285,948.00
210101	Үндсэн цалин	384,810,004.00	407,018,605.00
210102	Нэмэгдэл	00.00	153,601,397.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	22,513,656.00
210104	Урамшуулал	00.00	44,152,290.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,167,368.00	77,151,976.00
210201	Тэтгэврийн даатгал	47,167,368.00	53,152,898.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	6,253,280.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	3,415,802.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	3,251,041.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	11,078,955.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,656,002.38	123,756,142.42
210301	Гэрэл, цахилгаан	2,869,358.58	4,812,200.42
210302	Түлш, халаалт	90,469,211.80	109,985,322.00
210303	Цэвэр, бохир ус	8,317,432.00	8,958,620.00

Хүүхдийн Тэмүүжин театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2104	Хангамж, бараа материалын зардал	38,492,000.00	23,028,200.00
210401	Бичиг хэрэг	2,106,300.00	5,677,500.00
210402	Тээвэр, шатахуун	7,575,100.00	9,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	471,900.00	578,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	442,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,468,300.00	7,130,000.00
210408	Бараа материал акталсны зардал	26,270,400.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,331,000.00	34,135,128.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	23,935,128.00
210604	Урсгал засвар	14,331,000.00	10,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,313,000.00	2,664,000.00
210702	Дотоод албан томилолт	6,313,000.00	2,664,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,409,550.00	61,996,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,229,550.00	59,976,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	1,020,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,392,853.26	45,476,848.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,331,200.00	6,013,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,061,653.26	39,463,648.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	159,811,678.58	192,333,519.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	153,697,534.00	25,968,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	9,120,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	107,215,600.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,713,934.00	16,848,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	166,167,461.93
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	166,167,461.93
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,626,297.62	197,757.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,626,297.62	197,757.58
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,487,846.96	00.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	4,487,846.96	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	172,753,091.92	24,856,006.90
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	172,753,091.92	24,856,006.90

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	944,721,548.14	1,190,700,255.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,279,800.00	52,893,350.00
120	Нийтлэг татварын бус орлого	28,279,800.00	52,893,350.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,279,800.00	52,893,350.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,769,800.00	52,893,350.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,510,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	916,441,748.14	1,137,806,905.25
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	798,259,448.14	1,004,653,005.25
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	798,259,448.14	1,004,653,005.25
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	118,182,300.00	133,153,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	118,182,300.00	133,153,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	821,930,306.00	1,186,461,705.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	821,930,306.00	1,186,461,705.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	666,606,474.38	994,128,186.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	387,903,804.00	624,192,148.00
210101	Үндсэн цалин	287,201,168.00	403,924,805.00
210102	Нэмэгдэл	59,479,930.00	153,601,397.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,127,085.00	22,513,656.00
210104	Урамшуулал	24,095,621.00	44,152,290.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,167,368.00	77,151,976.00
210201	Тэтгэврийн даатгал	32,708,853.00	53,152,898.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,848,093.00	6,253,280.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,078,481.00	3,415,802.00
210204	Ажилгүйдлийн даатгал	684,720.00	3,251,041.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,847,221.00	11,078,955.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,656,002.38	123,756,142.42
210301	Гэрэл, цахилгаан	2,869,358.58	3,852,780.42
210302	Түлш, халаалт	90,469,211.80	109,985,322.00
210303	Цэвэр, бохир ус	8,317,432.00	9,918,040.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,221,600.00	24,791,400.00
210401	Бичиг хэрэг	2,063,400.00	7,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,618,000.00	9,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	471,900.00	748,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	442,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,468,300.00	7,200,000.00

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,090,000.00	40,218,620.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,190,000.00	30,018,620.00
210604	Урсгал засвар	14,900,000.00	10,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,313,000.00	2,664,000.00
210702	Дотоод албан томилолт	6,313,000.00	2,664,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,242,200.00	96,553,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,062,200.00	94,133,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	1,420,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,012,500.00	4,800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,012,500.00	4,800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	155,323,831.62	192,333,519.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	153,697,534.00	25,968,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	9,120,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	107,215,600.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,713,934.00	16,848,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	166,167,461.93
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	166,167,461.93
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,626,297.62	197,757.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,626,297.62	197,757.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	122,791,242.14	4,238,549.32
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	45,595,000.00	98,102,080.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	45,595,000.00	98,102,080.00
2200	Дотоод эх үүсвэрээр	45,595,000.00	98,102,080.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	45,595,000.00	98,102,080.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-45,595,000.00	-98,102,080.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	77,196,242.14	-93,863,530.68
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,667,288.54	93,863,530.68
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	93,863,530.68	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-46,789,837.68	114,260,961.01
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-46,789,837.68	114,260,961.01
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-946,053.37	-946,053.37
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	208,355,392.93	369,406,191.62
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	208,355,392.93	369,406,191.62
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	24,856,006.90	24,856,006.90
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	233,211,399.83	394,262,198.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		93863530.68		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,190,700,400.00	1,118,198,566.42	72,501,833.58	93.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,190,700,400.00	1,118,198,566.42	72,501,833.58	93.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,164,732,100.00	1,092,230,266.42	72,501,833.58	93.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	687,647,500.00	624,192,148.00	63,455,352.00	90.8
210101	Үндсэн цалин	425,964,000.00	403,924,805.00	22,039,195.00	94.8
210102	Нэмэгдэл	173,168,800.00	153,601,397.00	19,567,403.00	88.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,240,000.00	22,513,656.00	4,726,344.00	82.6
210104	Урамшуулал	61,274,700.00	44,152,290.00	17,122,410.00	72.1

Хүүхдийн Тэмүүжин театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,955,900.00	77,151,976.00	8,803,924.00	89.8
210201	Тэтгэврийн даатгал	58,450,100.00	53,152,898.00	5,297,202.00	90.9
210202	Тэтгэмжийн даатгал	6,876,500.00	6,253,280.00	623,220.00	90.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,438,200.00	3,415,802.00	22,398.00	99.3
210204	Ажилгүйдлийн даатгал	3,438,200.00	3,251,041.00	187,159.00	94.6
210205	Эрүүл мэндийн даатгал	13,752,900.00	11,078,955.00	2,673,945.00	80.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	123,953,900.00	123,756,142.42	197,757.58	99.8
210301	Гэрэл, цахилгаан	4,000,000.00	3,852,780.42	147,219.58	96.3
210302	Түлш, халаалт	110,003,900.00	109,985,322.00	18,578.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	9,950,000.00	9,918,040.00	31,960.00	99.7
2104	Хангамж, бараа материалын зардал	24,800,000.00	24,791,400.00	8,600.00	100.0
210401	Бичиг хэрэг	7,200,000.00	7,200,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	9,200,000.00	9,200,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	748,800.00	151,200.00	83.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	442,600.00	-142,600.00	147.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,200,000.00	7,200,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	112,320,700.00	112,320,700.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	102,120,700.00	102,120,700.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	10,200,000.00	10,200,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,700,000.00	2,664,000.00	36,000.00	98.7
210702	Дотоод албан томилолт	2,700,000.00	2,664,000.00	36,000.00	98.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	122,554,100.00	122,553,900.00	200.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,134,100.00	120,133,900.00	200.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,420,000.00	1,420,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4800000.00	4800000.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,800,000.00	4,800,000.00	0.00	100.0

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25968300.00	25968300.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,968,300.00	25,968,300.00	0.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,120,300.00	9,120,300.00	0.00	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,848,000.00	16,848,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,190,700,400.00	1,190,700,255.25	144.75	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,004,653,100.00	1,004,653,005.25	94.75	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,004,653,100.00	1,004,653,005.25	94.75	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	133,153,900.00	133,153,900.00	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	133,153,900.00	133,153,900.00	0.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	52,893,400.00	52,893,350.00	50.00	100.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,893,400.00	52,893,350.00	50.00	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	93,863,530.68	-93,863,530.68	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	0.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27	26	1	96.3
620001	Удирдах ажилтан	2	1	1	50.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	7	7	0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27	26	0	96.2
650006	Соёл урлагийн салбарын терийн йлчилгээний албан хаагч (ТҮСҮ)	19	18	0	94.7
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8	0	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүүжин театр нь хүүхэд багачуудыг бага наснаас нь үндэсний соёлын мэдрэмж, мэдлэг, хүмүүжил төлөвшлийг олгож, авьяас чадварыг нь нээн хөгжүүлж, сэтгэлгээний бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрх чөлөөг хангаж хүүхдийн урлагийн бүтээлээр үндэсний нэрийн хуудас болно гэсэн эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын дотоод аудит/аудиторын чиг үүргийг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба тайлант онд шилэн дансны шалгалт хийгдсэн талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүүжин театрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, журмуудыг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүүжин театр нь 2024 оны санхүүгийн тайланг “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24,856.0 мянган төгрөг буюу 6,7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	208,410.9	152,644.1	-55,766.8
МӨНГӨН ХӨРӨНГӨ	93,863.5	00.0	-93,863.5
АВЛАГА	3,520.9	427.1	-3,093.8
БАРАА МАТЕРИАЛ	111,026.5	152,217.0	41,190.4
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	160,995.1	241,618.0	80,622.8
Хуримтлагдсан элэгдэл	-209,960.2	-249,423.9	-39,463.6
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	369,406.1	394,262.1	24,856.0
Засгийн газрын хувь оролцоо	369,406.1	394,262.1	24,856.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	369,406.1	394,262.1	24,856.0

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 0 төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 93,863.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны зарцуулаагүй үлдэгдэл 166,365,1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 427.3 мянган төгрөг болж 3,093.8 мянган төгрөгөөр буурсан байгаа нь өмнөх оны ХХОАТ-ын авлагаас тайлант онд 3,093.8 мянган төгрөгийг суутгаж 427.3 мянган төгрөгийн авлага үлдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 152,217.0 мянган төгрөг болж 41,190.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бусад хангамжийн материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 40,640.4 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 241,618.0 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 80,622.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 73,325.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 550.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 26,000.0 мянган төгрөгөөр дууны фонограмм, жүжгийн зохиол, баримтат кино зэргийг худалдаж авсан, аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 11-р сарын 18-ны өдрийн 99 дүгээр захирамжид үндэслэн ОНХС-ийн хөрөнгөөр 20,000.0 мянган төгрөгийн мастер морин хуур, Соёл спорт аялал жуулчлалын яамнаас 1,984.4 мянган төгрөгийн даралтат хөгжим ирснийг орлогод авсантай холбоотой байна.

Тайлант онд тус байгууллагад өглөг үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 394,262.1 мянган төгрөг болж 24,856.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 24,856.0 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,004,653.1 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 133,153.9 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас 52,893.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,190,700.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1,004,653.1 мянга, орон нутгийн төсвөөс 133,153.9 мянга, өөрийн үнсэн үйл ажиллагаанаас 52,893.4 мянган төгрөг, нийт 1,190,700.4 төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,004,653.0 мянга, орон нутгийн төсвөөс 133,153.9 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 52,893.5 мянга, оны эхний үлдэгдэл 93,863.5 мянга, урсгал үйл ажиллагаанд 1,118,198.5 мянган төгрөгийг зарцуулж, 166,167.4 мянган төгрөгийг улсын төсөвт, 197.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,118,198.5 мянган төгрөг буюу нийт батлагдсан төсвийн 93.9 хувийг зарцуулсан байгаа нь тайлант онд гүйцэтгэлээр 1 удирдах ажилтны орон тоо дутуу ажилласантай холбогдуулан цалин хөлсний зардлаас 63,455.3 мянган төгрөг хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71702 Соёл урлаг		1,190,700.4	1,118,198.5	72,501.8	93.9
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	887,003.2	814,699.3	72,303.8	91.8
2	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	133,153.9	132,956.1	197.7	99.9
3	80214 Уран бүтээлийн хийлгэх	40,000.0	40,000.0	0.00	100.0
4	80802 Тэтгэмж	16,848.0	16,848.0	0.00	100.0
5	81855 Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	60,801.9	60,801.7	0.2	100.0
6	83603 Өөрийн үйл ажиллагааны орлого	52,893.4	52,893.4	0.00	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Байхгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүүхдийн Тэмүүжин театрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хүүхдийн Тэмүүжин театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дугаар сарын 21-ны өдрийн 07/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв болох 1,190,700.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 17,860.5 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 11,609.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих цалингийн зардлаас бусад 5 саяас дээш дүнтэй орлогын 1,148,439.8 мянган төгрөгийн 27 гүйлгээ, зарлагын 439,945.2 мянган төгрөгийн 28 гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2023 оны санхүүгийн тайлангийн аудитыг Номгон аудит ХХК-ий аудитор О.Мандах гүйцэтгэсэн бөгөөд тус аудитаар 877.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт хүргүүлснээс биелэлт 100 хувь байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	-	-	-	-	0
Төлбөрийн акт	2	877.7	2	877.7	100
Албан шаардлага	0	-	-	-	0
Нийт дүн	2	877.7	2	877.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Тус байгууллага нь үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу байгууллагын дагаж мөрдөх хуулийн хүрээнд болон санхүүгийн зарчмын хувьд хууль, дүрэм журмыг зөрчөөгүй 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгөх санал хүргүүлээ.

6. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Хүүхдийн Тэмүүжин театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ					1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ					1			

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----